

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ СИСТЕМИЙН
АЖЛЫН ДААЛГАВАР

Програм боловсруулах зөвлөх үйлчилгээ

Стратегийн удирдлагын газар

4/9/2018

Агуулга

| | |
|--|----|
| Нэг. Ерөнхий зүйл | 3 |
| 1.1 Системийн хэрэгцээ шаардлага:..... | 3 |
| 1.2 Системийн зорилго | 3 |
| 1.3 Системийн ач холбогдол | 4 |
| 1.4 Системийн хамрах хүрээ | 4 |
| 1.4 Зөвлөх үйлчилгээний хэрэгжих хугацаа | 4 |
| 1.5 Зөвлөх үйлчилгээний үе шат | 4 |
| 1.6 Зөвлөх үйлчилгээний зохион байгуулалт, хамтран ажиллах баг | 5 |
| Хоёр. Системийн шаардлага буюу зөвлөхийн хийх ажил | 5 |
| 2.1 Системийн үндсэн шаардлага..... | 5 |
| 2.2.2 Системийн тусгай шаардлага..... | 6 |
| Гурав. Хүлээгдэж буй үр дүн | 9 |
| Дөрөв. Хавсралт..... | 9 |
| Хавсралт №1 Хараат бус аудитын компанийн талаарх ерөнхий мэдээллийн бүтэц, агуулга..... | 9 |
| Хавсралт №2 Системийг хөгжүүлэх, нэвтрүүлэх ажлын төсөв..... | 10 |
| Хавсралт № 3 Системийн зарим өгөгдөл..... | 11 |



**ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИАЛГААР САНХҮҮГИЙН
АУДИТ ГҮЙЦЭТГЭСЭН ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ
СИСТЕМИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Системийн хэрэгцээ шаардлага:

Төрийн аудитын байгууллага харьцангуй хязгаарлагдмал нөөцөөр түүнээс давсан их ачаалал, өргөн цар хүрээг хамарсан аудит хийдэг. Энэ асуудлыг шийдвэрлэхдээ Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д заасны дагуу аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг.

Гэрээгээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журмаар зохицуулдаг бөгөөд гэрээний хэрэгжилт, ажлын үр дүнгийн талаарх мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, цаашдын бодлого, үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж, зохион байгуулах шаардлага зүй ёсоор тулгардаг.

Иймд төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллаж буй хараат бус аудитын компанийн гэрээний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэн цуглуулж, дүн шинжилгээ хийх програм хангамж боловсруулж, гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнг богино хугацаанд нэгтгэсэн байдлаар хянаж, дүн шинжилгээ хийх хэрэгцээтэй байна.

1.2 Системийн зорилго

Гэрээний үндсэн дээр гүйцэтгэж байгаа санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх системийн зорилго нь төрийн аудитын байгууллагын захиалгаар санхүүгийн тайлангийн аудит хийсэн хараат бус аудитын компанийн гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлэн цуглуулж, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангах, цаашид хараат бус аудитын компанитай хамтран ажиллах боломж, нөхцөл, ажлын цар хүрээ зэрэг аудитын стратеги тодорхойлох мэдээлэл боловсруулахад оршино.

Энэхүү төсөл арга хэмжээ нь Төрийн аудитын байгууллагаас дэвшүүлж буй орчин үеийн дэвшилтэт техник технологид суурилсан цахим аудитын тогтолцоо бий болгож, төлөвшүүлэх зорилгод бүрэн нийцэж байгаа тул шинээр боловсруулах програм хангамжийг цаашид энэ бодлогын хүрээнд аудитын бусад системтэй уялдуулан хөгжүүлнэ.

1.3 Системийн ач холбогдол

Дээрх систем бий болсноор санхүүгийн тайлангийн аудитын талаар тухайн тайлант хугацаанд баримтлах бодлого, стратегийг нэгтгэсэн байдлаар тодорхойлоход шаардлагатай мэдээллийн тоо, чанар, үр нөлөө сайжирч, аудитыг оновчтой төлөвлөх боломж, нөхцөл сайжрах юм.

Аудитыг нэгтгэсэн байдлаар оновчтой төлөвлөх нь аудитын чанар, үр нөлөө дээшилж, төрийн аудитын байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ чанартай, үр өгөөжтэй гүйцэтгэх томоохон хүчин зүйл юм.

Энэхүү зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлснээр хөрөнгө, нөөц хэмнэх бөгөөд хөгжиж буй мэдээллийн технологийн хөгжил, дэвшлийг аудитад нэвтрүүлэх зорилготой нийцэх юм.

1.4 Системийн хамрах хүрээ

Энэхүү систем нь гэрээний үндсэн дээр хийлгэсэн санхүүгийн тайлангийн аудитын¹ бүхий л үйл явцад хамаарах бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх батлагдсан үзүүлэлтийн дагуу холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр цуглуулах, дүн шинжилгээ хийх, батлагдсан загвар - маягтын дагуу төрөл бүрийн статистик тайлан, мэдээ гаргах цогц систем байх болно.

Системд Үндэсний аудитын газар нь удирдлага, зохион байгуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж, 21 Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын байгууллага, түншлэлийн гэрээний үндсэн дээр төрийн аудитын байгууллагатай хамтран ажилладаг Хараат бус аудитын компанийн 400 орчим хэрэглэгчид системд хандаж, үйл ажиллагаа явуулах юм.

1.4 Зөвлөх үйлчилгээний хэрэгжих хугацаа

- Суурь судалгаа – 1 сар
- Програм хангамж боловсруулах, хөгжүүлэх: 2 сар
- Суурилуулах: ажлын 10 хоног
- Турших: 15 хоног
- Сургалт зохион байгуулах: 1 сар
- Програмын баталгаат хугацаа: 18 сар

1.5 Зөвлөх үйлчилгээний үе шат

Зөвлөх үйлчилгээ дараах үе шатад хуваагдана:

1. Програм хангамж боловсруулах, турших
2. Програм хангамжийг төрийн аудитын байгууллагын холбогдох ажиллагсдын компьютерт суурилуулах, хэрэглэгчийг бүртгэх, эрх нээх

¹ Төрийн аудитын байгууллагын хэмжээнд 2017 онд ... санхүүгийн тайлангийн аудитыг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн

3. Туршилт, судалгаа

4. Сургалт

Үе шат тус бүрийг захиалагч үнэлж, баримтжуулна

1.6 Зөвлөх үйлчилгээний зохион байгуулалт, хамтран ажиллах баг

Зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх явцад Үндэсний аудитын газрын Стратегийн удирдлагын газар, Тамгын газар, Санхүүгийн аудитын газар хамтран ажиллаж, тендерт шалгарсан зөвлөхийг мэдээллээр хангана.

Системийн шаардлагыг хэрэгжүүлэх явцад хийх ажил үүрэг, шаардлагад нэмэлт өөрчлөлт гарч болно.

Гарсан өөрчлөлтийг захиалагч зөвлөхтэй тухай бүр харилцан тохиролцож, ажлын даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулж, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Гүйцэтгэгч нь ажлын явц, гүйцэтгэлийн талаарх тайланг үе шат тус бүрээр Үндэсний аудитын газарт бичгээр тайлагнана.

Хоёр. Системийн шаардлага буюу зөвлөхийн хийх ажил

2.1 Системийн үндсэн шаардлага

Системийн үндсэн шаардлага нь төрийн аудитын байгууллагын захиалгаар санхүүгийн тайлангийн аудит хийсэн хараат бус аудитын компанийн гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой үзүүлэлтүүднийг цахим хэлбэрт шилжүүлэн цуглуулах, огөгдсөн бодлого, аргачлалын дагуу мэдээллийг нэгтгэн, дүн шинжилгээ хийх, батлагдсан загвар - маягтын дагуу төрөл бүрийн статистик мэдээ, тайланг цахим хэлбэрээр бэлтгэх, холбогдох мэдээллийн сан бий болгож, удирдах үйл явцыг програмчилна.

Зөвлөх Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал”-д дурдсан бодлого, аргачлалыг системийн үндсэн шаардлага гэж үзэх бөгөөд бусад мэдээллийг Санхүүгийн аудитын журам, гарын авлага, Аудитын олон улсын стандартаас судалж, системийг бүхэлд нь эдгээр шаардлагад бүрэн нийцүүлнэ.

Зөвлөхийн санал боловсруулахад анхаарах асуудал

1. Төрийн аудитын байгууллагатай хамтран ажиллах хараат бус аудитын компанийн талаарх ерөнхий мэдээллийг Сангийн яам, ММНБИ-ийн мэдээллийн сангаас цахим хэлбэрээр тогтмол хугацаанд хүлээн авч, систем дэх хэрэглэгчийн мэдээллийг автоматаар шинэчлэх боломжтой болгох. Хараат бус аудитын компанийн талаарх ерөнхий мэдээллийн бүтэц, агуулгыг Хавсралт № 1-д үзүүлэв.
2. Шинээр боловсруулах систем нь Төрийн аудитын байгууллагын Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системтэй шууд холбогдож, хараат бус аудитын компанийн гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын үе шатны ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаарх шаардлагатай мэдээлэл солилцох боломжтой байх.

3. Гэрээгээр гүйцэтгэсэн аудитын ажлын гүйцэтгэлийг тооцох, үр дүнг үнэлэх, тайлагнах аргачлал, үндсэн үзүүлэлтийг сонгохдоо энэ даалгаврын 2.1-д заасан Заавар, аргачлалд үндэслэнэ. Ажлын гүйцэтгэлийг тооцох, үр дүнг үнэлэх үзүүлэлтийг хэрэглэгч өөрөө нэмэх, хасах боломжтой байх.
4. Тухайн хараат бус аудитын компанитай холбоотой гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүн болон системийн гол үр дүнгийн талаарх олон жилийн динамик мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, ашиглах боломж бий болгох
5. Системийн хэрэглэгчийг системд хандах эрх хэмжээгээр нь ангилан тодорхой хязгаарлалт хийж болохоор програмчлах
6. Хэрэглэгчид өөр өөрийн эрх хэмжээгээр програмд нэгэн зэрэг хандаж, мэдээлэл оруулах, удирдлагууд үнэлгээний явц, гүйцэтгэлийг хянах, баталгаажуулах, заавар чиглэл өгч, хариу авах үйл явц иж бүрэн цахим хэлбэрээр хийгдэх боломжтой байхаар програмчлах. Системд нэвтрэх эрхийн хязгаарлалт дараах хэлбэртэй байж болно. Үүнд:
 - a. Мэдээлэл оруулж, баталгаажуулах
 - b. Хянаж, баталгаажуулах
 - c. Мэдээлэл оруулах, хянах, баталгаажуулах
 - d. Програмд тохируулга хийх эрх бүхий admin
7. Хараат бус аудитын компанийн төлөөлөл өгөгдсөн эрх хэмжээний дагуу системд нэвтрэх гэрээний үндсэн дээр гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой нэмэлт мэдээллийг системд оруулж, баталгаажуулах боломжоор хангах
8. Хэрэглэгч тус бүрийн системд хандаж хийсэн ажлын талаарх түүхийг төрөл бүрээр үлдээж хадгалах, үнэлэх боломж бий болгох дэд функцтэй байх
9. Системээс гарсан үр дүн, тайлагналыг өгөгдсөн загвар, заавар, журмын олон төлөв байдлаар харах, хэвлэх боломжоор хангах
10. Програмын статистикийн иж бүрэн бааз үүсгэж, програмчлах
11. Систем боловсруулахад шаардлагатай зарим өгөгдлийг хавсралт № 3-т үзүүлэв.

2.2.2 Системийн тусгай шаардлага

2.2.2.1 Системийг цаашид хөгжүүлэх шаардлагын талаар

Зөвлөх системийг цаашид хөгжүүлэх стратеги боловсруулж, захиалагчид танилцуулах бөгөөд энэ нь тендерийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэг байх болно.

Ижил төрлийн системтэй харьцуулсан судалгаа хийх.

2.2.2.2 Нууцлал ба аюулгүй байдлыг хангах шалгуур

Төрийн аудитын байгууллага төрийн ямар ч байгууллагын нууц мэдээлэлтэй өдөр тутам харьцаж, түүнийг тухайн байгууллагын ажиллагсадтай ижил түвшинд нууцлах үүрэг хүлээдэг. Иймд энэ системийн нууцлал ба аюулгүй байдал нэн чухал бөгөөд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх санал/шийдэл боловсруулж, захиалагчид хүргүүлэх.

Энэ систем нь газар хөдлөлт, хүчтэй салхи, үер ус зэрэг байгалийн давагдашгүй хүчин зүйл, зам тээвэр, харилцаа холбоо болон цахилгаан эрчим хүчний тасалдал, системийн уналт, мэдээллийн алдагдал, техник тоног төхөөрөмжүүдийн физик эвдрэл, сүлжээний доголдол, хэрэглэгчийн буруу үйл ажиллагаа, системийн зүй бус хэрэглээ зэрэг хүний оролцоотой холбоотой бусад төрлийн аюулаас найдвартай хамгаалагдсан байх ёстой.

Энэ шаардлагыг хангахын тулд дараах үзүүлэлтийг заавал авч үзнэ.

Нууцлал: Гуравдагч этгээдэд нууц мэдээлэл задрахаас хэрхэн хамгаалах

Бүрэн бүтэн байдал: Системийн доголдол, эсвэл зүй бус хэрэглээнээс үүдэн мэдээллийн цогц шинж чанар алдагдахаас хэрхэн сэргийлэх

Бэлэн байдал: Шаардлагатай үед хэрэгцээт мэдээллээр хангах, системийн бүх нөөцийг найдвартай эх үүсвэрээр хэрхэн хангах

2.2.2.4 Бусад тусгай шаардлага

Урьдчилсан судалгаа

Бусад улс орнуудад ашиглагддаг аудитын цахим удирдлагын системд нийтлэг шинж чанараар нь харьцуулсан судалгаа хийж, ажлын даалгавар, судалгааны дүнг харьцуулан дүгнэлт гаргаж, захиалагчид танилцуулах.

Шаардлагатай бол ажлын даалгаварт нэмэлт өөрчлөлт оруулах

Хэрэглэгчийн түвшний шаардлага:

- Програмын бүх цэс, ажилбарууд Монгол хэл дээр байх
- Хэрэглэхэд хялбар байх
- Мауз болон гарын аль алинаар мэдээлэл оруулах боломжтой байх
- Айкон, товчлолоор хангагдсан байх
- Логик хяналтыг аль болох өргөн ашиглах
- Undo, Redo боломжтой байх
- Чухал ажилбар, командын дараа баталгаажуулалт заавал шаардах

Загвар ба дизайн:

- Хэрэглэгчдийн интерфейс нь сайн зохион байгуулагдсан цонх, цэснүүдээс бүрдэх
- Цонх, цэсүүд ойлгомжтой байх
- Хурц тод өнгийн буюу хэрэглэгчийн нүдийг ядраах өнгөнүүдээс татгалзах

- Систем нь зөвхөн төрийн аудитын байгууллагуудад ашиглагдах тусгай зориулалтын, вэб технологид суурилсан програм хангамж байна.

Зөвлөхийн мэдлэг чадвар, туршлагын талаарх шаардлага

Зөвлөхийн үйлчилгээнд дараах шаардлагыг хангасан ажилтан оролцох боломжтой. Үүнд:

- Санхүү, нягтлан бодох бүртгэл, аудитын програм хангамжийг боловсруулах, нийлүүлэх, суурилуулах 2-оос доошгүй төсөл, арга хэмжээнд голлох үүрэгтэй оролцож байсан
- Програм хангамж үйлдвэрлэлийн салбарт 5-аас дээш жил ажилласан,
- Энэ программыг боловсруулахад дор хаяж мэргэжлийн 5 програмистыг бүтэн цагаар ажиллуулах боловсон хүчний нөөц бүхий, сүүлийн 3 жилд програм хангамжийн нарийн түвэгтэй байдал, үнэ өртөг, цар хүрээгээр ижил төстэй дор хаяж 1 төсөл амжилттай хэрэгжүүлсэн компаниуд оролцоно.

Сургалт

| | Сургалтын нэр | Хийх газар | Хугацаа | Хүний тоо |
|---|-----------------------|------------|---------|------------------------------------|
| 1 | Хэрэглэгчдийн сургалт | УБ | 3 хоног | Аймгийн аудитын газар бүрээс 2 хүн |
| 2 | Админы сургалт | УБ | 3 хоног | МТ-ийн ажилтнууд |

Гарын авлага

| | Гарын авлагын нэр | Зөөгч | Тоо ширхэг | Хэлбэр |
|---|---|--|---|--|
| 1 | Хэрэглэгчдийн гарын авлага /монгол хэлээр/ | Хэвлэмэл болон электрон хэлбэрээр авч УАГ вэб сайтад байршуулна. | ТА-ын байгууллагын аудитор, шинжээчдийн тоогоор | Энгийн ойлгомжтой хэлбэрээр МТ мэргэжлийн бус хүн ойлгохоор боловсруулж, цонх, функц, команд бүрийг скрин шотоор тайлбарлаж хийнэ. |
| 2 | Админ-ы гарын авлага /монгол хэлээр/ | Цахим | | Энгийн ойлгомжтой хэлбэрээр МТ мэргэжлийн бус хүн ойлгохоор боловсруулж, цонх, функц, команд бүрийг скрин шотоор тайлбарлаж хийнэ. |

**ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ
СИСТЕМИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

| | | | |
|----------|---|-------|---|
| 3 | Системийн талаарх гарын авлага, хэрэглэх заавар | Цахим | Системд текст болон медиа хэлбэрээр байршиж |
|----------|---|-------|---|

Гурав. Хүлээгдэж буй үр дүн

Зөвлөхийн үйлчилгээний дуусвар болоход ажлын даалгаврын 1.1-д заасан шаардлага бүрэн хангагдаж, 1.2-д заасан зорилгод хүрсэн байх ёстой.

Ажлын даалгаварт заасан үндсэн болон тусгай шаардлага, ажил үүргийн биелэлт, үр дүнг зөвлөх захиалагчид бичгээр тайлагнах бөгөөд 2 тал харилцан зөвшилцөж баталгаажуулна.

Дөрөв. Хавсралт

Хавсралт №1 Хараат бус аудитын компанийн талаарх ерөнхий мэдээллийн бүтэц, агуулга

| № | Оноосон нэр | Товчилсон нэр | Улсын бүртгэлийн дугаар | Тусгай зөвшөөрлийн | | Албан ёсны хаяг | Утас | Цахим шуудан | Веб хуудас |
|---|-------------|---------------|-------------------------|--------------------|------------------|-----------------|------|--------------|------------|
| | | | | Дугаар | Хүчинтэй хугацаа | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |

ХАРААТ БУС АУДИТЫН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГЭРЭЭТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ СИСТЕМИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Хавсралт № 3 Системийн зарим өгөгдөл

| Д.д | Үзүүлэлт | Тавигдах нөхцөл ба шаардлага, тайлбар |
|-----|-----------------------------------|--|
| 1 | Системийн оноосон нэр: | “Хараат бус аудитын хуулийн этгээдийн гүйцэтгэсэн санхүүгийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах систем” |
| 2 | Системийн тодорхойлолт: | Төрийн аудитын байгууллагын захиалгаар санхүүгийн аудит гүйцэтгэсэн хараат бус аудитын хуулийн этгээдийн гэрээт ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, тайлагнах үйл явцыг програмчилна. |
| 3 | Сервер компьютер: | Виртуал серверийн технологийг ашиглана. |
| 4 | Сүлжээний орчин: | Төрийн аудитын байгууллагын нэгдсэн сүлжээнд болон интернет орчинд ажиллана. |
| 5 | Мэдээлэл хадгалах ба сан үүсгэх: | Мэдээллийн сангийн сервер ҮАГ дээр байрлана. Мэдээллийн санг ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын аудитор, шинжээчид, аймгуудын аудитын газрын аудитор, шинжээчид, мөн хараат бус аудитын байгууллагын аудиторууд бүрдүүлнэ. |
| 6 | Өгөгдлийн сан | Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем нь: <ul style="list-style-type: none"> - Хараат бус аудитын хуулийн этгээдийн талаарх өгөгдлийн сан - Тайлан хугацаанд гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг цуглуулах өгөгдлийн сан - Ажлын гүйцэтгэлийг боловсруулах, тайлагнах маягт, аргачлалын сан - Хэрэглэгчийн мэдээллийн сан Өмнөх тайлант хугацааны ажлын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг цуглуулж, хадгалах архивын мэдээллийн сан |
| 7 | Хүчин чадал: | Програмын функц, модулийг хялбар өргөтгөх боломжтой, интернетийн болон компьютерийн бага үзүүлэлтэд хэвийн ажилладаг байхаар програмыг боловсруулах. |
| 8 | Хандалт ба кодчлол: | Нийтэд өргөн дэлгэрсэн, хамгийн орчин үеийн програмчлалын хэл, өгөгдлийн сангийн удирдлагын програмыг ашиглана. /Java, PHP, Oracle, MsSQL/ Програмын модуль, функц, кодын мөр нь стандартын дагуу дэлгэрэнгүй тайлбартай бичигдсэн байх. |
| 9 | Үйлдлийн бүртгэл | Хэрэглэгч болон админы програмд хийсэн аливаа үйлдэл, өөрчлөлтийн бүртгэл/log-ийг тогтмол хадгалдах байх. |
| 10 | Ашиглалтын горим ба зааварчилгаа: | Ашиглалтын горим зааварчилгааг Монгол хэл дээр үйлдэнэ. |
| 11 | Баталгаат хугацаа: | Програмыг талууд албан ёсоор хүлээн авч гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 18 сар байна. |
| 12 | Зохиогчийн эрх | Програм, түүний бүрдэл хэсэг, эх кодыг ҮАГ эзэмшинэ. |

БОЛОВСРУУЛСАН:

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ШИНЖЭЭН



Ж.БАТСАЙХАН

ТАМГЫН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ МЕНЕЖЕР



С.АЛТАНГЭРЭЛ

ХЯНСАН:

СТРАТЕГИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.ЭНХБОЛД

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ